



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/37

Амардалай

Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.13, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.6.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаар нутгийн иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн туршлага судлах сургалтын зардлыг Байгаль хамгаалах сангийн зардлаас зарцуулсугай.

2.Дээрх зардлын үнэ 5,200,000 (таван сая хоёр зуун мянган) төгрөгийн санхүүжилтийг Сумын байгаль хамгаалах сангаас зориулалтын дагуу гаргаж, зарцуулахыг нягтлан бодогч (Л.Амаржаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

М.БАЯРСҮХ